

Д.НАЦАГДОРЖИЙН НЭРЭМЖИТ УЛААНБААТАР ХОТЫН
НИЙТИЙН ТӨВ НОМЫН САН

ТАЙЛАН


2025 оны 12 дугаар сарын 23

Улаанбаатар хот

Номын сангийн ёс зүйн зөвлөлийн
2025 онд хийж гүйцэтгэсэн ажлын тухай

Тус номын сангийн ёс зүйн зөвлөлийн гишүүд нь ажилчдыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, хууль тогтоомжид заасан эрх үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, харилцааны болон ёс зүйн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:


- ✓ Ёс зүйн хорооны соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүү “Төрийн албан хаагчийн ёс зүй, хууль тогтоомж” сэдвээр сургалт зохион байгуулсан.






- ✓ Тайлант хугацаанд Ёс зүй гэж юу вэ? сэдэвт сургалтыг Ёс зүйн зөвлөлийн гишүүн А.Энхжаргал удирдан явуулж ЧД дүүрэг дэх салбар номын сангийн ажилтнуудад мэдлэг, мэдээлэл өгч сургалтад нийт 5 ажилтан албан хаагч хамрагдсан.



- ✓ Хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйг төлөвшүүлэх эерэг хандлагыг нэмэгдүүлэх үүднээс олон нийтийн соёлын арга хэмжээнд жигд хувцастай болгосон.



- ✓ Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг байгууллагын 40 албан хаагчдаас түүвэрлэн эрсдлийн үнэлгээнд хамруулсан. Үнэлгээгээр байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, соёлын тухайд тохиолдож буй бэрхшээл харьцангуй бага эрсдэл маш ховор тохиолддог гэж үнэлэгдсэн байна.
- ✓ Тайлант хугацаанд ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн, ажлын сахилга хариуцлага алдсан албан тушаалтан байхгүй. Урьдчилан сэргийлэх үүднээс ёс зүйн нөлөөллийн мэдүүлгийн талаар байгууллагын дотоод сүлжээ болон мэдээллийн самбарт байршуулсан.
- ✓ Ёс зүйн зөвлөлийн гишүүд Ажилтны сэтгэл ханамжийн судалгаа, номын сангаар үйлчлүүлж буй уншигч хэрэглэгчдээс ажилтан, албан хаагчдын харилцаа хандлагын талаарх судалгаа авч, үр дүнг нэгтгэн танилцуулсан. Судалгаанд нийт 23 албан хаагч 50 уншигч хамрагдсан.
- ✓ Тус номын сангийн ёс зүйн зөвлөл нь байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан шинэчилсэн ёс зүйн дүрмийг боловсруулж эхлээд байна. 2026 онд батлуулан хэрэгжүүлж ажиллана.
- ✓ Байгууллагад шинээр ажилд орж байгаа ажилтнуудад тухайн байгууллагын дүрэм, журам, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, хууль тогтоомжид заасан хүний эрх чөлөөг хүндэтгэх, харилцааны болон ёс зүйн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдээ, мэдээллийг ёс зүйн зөвлөлийн дарга М.Отгонбаяр өгсөн.
- ✓ Албан хаагч нарыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Төрийн туульч СГЗ Э.Баатаржав “Алтайн магтаал”, Баян цагаан өвгөн туульсыг хайлж, урианхайн ховор нандин соёлын өв болох тууль хайлах ёсны талаар танилцуулсан. Мөн “Гэмт хэрэг, ёс зүйн зөрчлөөс сэргийлье” сэдэвт ном гарын авлагаар үзэсгэлэн болон Ажилчдын дотоод цахим хуудсаар дамжуулан Дэлхийн ёс зүйн өдрийг тохиолдуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчмуудыг таниулсан постер бэлтгэн хүргэсэн байна.



- ✓ Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол мэдээлэл бүртгэгдээгүй. Хянан шалгах чиг үүргийн хүрээнд холбогдох этгээдэд шилжүүлсэн гомдол мэдээлэл байхгүй.
- ✓ Байгууллагын пэйж хуудсаар дамжуулан “Хүмүүжлийн хэв маяг”, Ёс суртахууны тухай ойлголт” цахим мэдээллийг 2 удаа бэлтгэн хүргэсэн.



ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН
ЗАХИРАЛ



Д.ИНДРА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН
ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

М.ОТГОНБАЯР